



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/046/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a> Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:suvdaaa@audit.gov.mn">suvdaaa@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс:7034-2580  
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 202

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авллага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, батлагдаагүй орон тоонд гэрээгээр ажилтан авч ажиллуулсан, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

632502322

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2023 оны XIX/08 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос өссөн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГТИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	121,454.1	131,567.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,125,971.6	4,103,450.6
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,247,425.7</b>	<b>4,235,018.2</b>
Нийт өр төлбөрийн дүн	3,502.2	2,925.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,243,923.5	4,232,092.4
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,247,425.7</b>	<b>4,235,018.2</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,715,089.8	2,611,396.2
Үйл ажиллагааны зардлын дүн	1,412,701.1	1,623,227.3
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>302,388.7</b>	<b>988,168.9</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	50,756.4	-
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>320,681.5</b>	<b>988,168.9</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,983,724.6	3,243,923.5
Тайлант оны үр дүн	300,681.5	988,168.9
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>3,243,923.5</b>	<b>4,232,092.4</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,013,704.2	1,361,477.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	913,406.6	1,270,075.6
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>100,297.6</b>	<b>91,401.9</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(100,297.6)</b>	<b>(91,401.9)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>		<b>1,165,927.2</b>
Урсгал зардал		1,165,927.2
Хөрөнгийн зардал		-
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>		<b>1,165,927.2</b>
Орон нутгийн төсвөөс		1,165,927.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага “Тамгын газрын эрхэм зорилго нь Засаг даргын бүрэн эрхээ тасралтгүй, хэвийн, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, иргэдэд түргэн шуурхай, ил тод нээлттэйгээр төрийн үйлчилгээг хүргэхэд оршино” зорилгын хүрээнд ажилласан байна

### Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,152,220.5 мянган төгрөгийн орлогын 44 гүйлгээ, зарлагын 30,845.9 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай

хуулийн 6.4.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.10-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

## **Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулсан эсэх, 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг болон элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хянах үзэх.

## **Зургаа. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 901,085.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Үнэ төлбөргүй ирсэн 891,257.6 мянган төгрөгийн хөрөнгийг тайлан бүртгэлд дутуу тусгасан нь УСНББОУС-17, оршин байх батламж мэдэгдэл,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 1,214.6 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон нь УСНББОУС-17, тасалбар болголт батламж мэдэгдэл,
- Хагас жилийн нярвын бараа материалын тайлан баталгаажсан санхүүгийн тайлангийн дүн 8,510.5 мянган төгрөгөөр зөрүүтэй УСНББОУС-12, тасалбар болголт батламж мэдэгдэл,
- Бүртгэл, тооцооллыг алдаатай хийснээс 103.2 мянган төгрөгийн авлага дутуу тусгасан УСНББОУС-1,2 тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 65,006.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 810.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 28,671.2 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 35,525.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж, сахилгын хариуцлага хүлээлгэх 1 албан шаардлагыг өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 65,006.9 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 43,816.4 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### **6.1 Төлбөрийн акт**

1. Төсвийн хөрөнгөөр 810.0 мянган төгрөгийн хувцас бэлтгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг улсын орлого болгох.

### **6.2 Албан шаардлага**

1. ЗДТГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны А/21 тоот тушаалаар тооллогын комисс томилон тооллогыг явуулсан ч үнэн зөв хийгээгүй, чанаргүй гүйцэтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.3, 20.2.6, Төрийн болон

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, Төсвийн тухай хуулийн 16.5.7-д заасныг зөрчсөн, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

2. Тайлант онд 3,502.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.6 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж хэвших

3. Тайлант онд 4,924.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.6 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж хэвших

4. Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6,944.7 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 14.4.2, 20.2.3 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу тайлагнах

5. Тайлант онд нэмэлт санхүүжилтээс 3,000.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 14.4.2, 20.2.3 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу тайлагнах

6. Тайлант онд батлагдаагүй орон тоо болох манаач, 100 жил тохижилтын ажилд туслах ажилтан, усжуулагчаар 3 хүн авч ажиллуулан үндсэн цалингийн зардлаас 10,300.0 мянган төгрөгийг цалинжуулан зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг таслан зогсоож, төсвийг зориулалтын дагуу зарцуулах

7. Тайлант онд батлагдаагүй орон тоо болох манаач, 100 жил тохижилтын ажилд туслах ажилтан, усжуулагчаар нийт гурван хүн авч ажиллуулан үндсэн цалингийн зардлаас цалинжуулж албаны эрх мэдлээ хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, 70.1, Төрийн албаны тухай хуулийн 39.1.2 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны төсвийн захирагчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх

### **6.3 Зөвлөмж**

1. Бэлэн мөнгөний тайлантай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Няравын дансаар нийт 35,525.7 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн ч бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталгаажсан журмын дагуу тайлагнах.

**2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 49 нэр төрлийн 79 тооны хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.

**3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд тус сумын 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан ч ойн хүрээнд иргэд, байгууллагаас хандив, тусламжаар өгсөн хөрөнгийг тайлан бүртгэлд тусгаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолын дагуу хөрөнгийг хүлээж авах, тайлан бүртгэлд тусгах.

**4. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Эхний хагас жилийн тайланг санхүүгийн программаар тайлагнаагүй, тооцоо нийлсэн акт байхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** НББ-ийн тухай хуулийн 9, Төсвийн тухай хуулийн 14.2-д заасны дагуу эхний хагас жилийн тайланг үнэн зөв тайлагнах.

**Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хутаг-Өндөр сумын ЗДТГ	4	901,085.9	3	892,575.4	1	8,510.5	4	901,085.9	0	0	0	0
Дүн	4	901,085.9	3	892,575.4	1	8,510.5	4	901,085.9	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хутаг-Өндөр сумын ЗДТГ	11	65,006.9	1	810	6	28,671.2	3	35,525.7	1	1	0	0
Дүн	11	65,006.9	1	810	6	28,671.2	3	35,525.7	1	1	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хутаг-Өндөр сумын ЗДТГ	1	1,183,066.5	0	-	1	1,183,066.5	0	-
Дүн	1	1,183,066.5	0	0	1	1,183,066.5	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эхний хагас жилийн тайланг санхүүгийн программаар тайлагнаагүй	1	-					1	-
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Нийт дүн	2	1,183,066.5	0	0	1	1,183,066.5	1	0

**Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		